

**“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛАХ
ОНЦГОЙ НӨХЦӨЛ БҮХИЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ**

2024 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 2024/01

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ш.Ганзориг (цаашид “ажил олгогч” гэх), нөгөө талаас “Дулаан Шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал П.Баярцэцэг (цаашид “гүйцэтгэх захирал”, хамтад нь “талууд” гэх) нар Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.9, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, 65.2-т заасныг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл


1.1. Энэхүү гэрээний зорилго нь “Дулаан Шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах, талуудын харилцан эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход оршино.

1.2. Энэхүү гэрээ нь 2024 он 04 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн 2025 оны 04 дүгээр сарын хуяцаа эзэшигчдийн хурал хүртэлх хугацаанд хүчинтэй байна.

1.3. “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2023 оны жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланд тусгагдсан 6,121,880,992.40 /зургаан тэрбум нэг зуун хорин нэгэн сая найман зуун наян мянга есөн зуун ерэн хоёр төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн үндсэн, 407,477,891.91 /дөрвөн зуун долоон сая дөрвөн зуун далан долоон мянга найман зуун ерэн нэгэн төгрөг ерэн нэгэн мөнгө/ төгрөгийн эргэлтийн, нийт 6,529,358,884.31 /зургаан тэрбум таван зуун хорин есөн сая гурван зуун тавин найман мянга найман зуун наян дөрвөн төгрөг гучин нэгэн мөнгө/ төгрөгийн хөрөнгийг гэрээ байгуулсан өдөр хүлээлгэн өгөв.

1.4. Эрчим хүчний яамнаас баталсан “Дулаан Шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,

Ажил олгогчийг төлөөлж:


.....Ш.Ганзориг
(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:


.....П.Баярцэцэг
(нэр, гарын үсэг)

хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд гүйцэтгэх захирлын гүйцэтгэх ажлын хүрэх үр дүн болно.

1.5. Эрчим хүчний яам гэрээний биелэлтийг жилийн эцсийн тайлан тэнцэл хэлэлцэх болон гэрээний хугацаа дуусгавар болох үед дүгнэнэ.

1.6. Гэрээг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан үндсэн болон эргэлтийн хөрөнгийг сүүлийн байдлаар хүлээлгэн өгнө.

Хоёр. Ажил олгогчийн эдлэх эрх, хүлээх үүрэг

2.1. Гүйцэтгэх захиралд цалин хөлс, ажлын үр дүнд нь тохирсон шагнал, урамшууллыг энэхүү гэрээнд заасан нөхцөлийн дагуу олгох;

2.2. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

2.3. Компанийн цэвэр ашгаас терд төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, үйлдвэрлэлийн болон орлогын өсөлт, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр зэргийг харгалзан батлах;

2.4. Компанийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тоо, цалингийн сангийн хэмжээг батлах;

2.5. Компанийн үйл ажиллагааны онцлог, ажлын шаардлагыг харгалзан удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилон ажиллуулах;

2.6. Гүйцэтгэх захирал 30-аас дээш хоногийн хугацаагаар эзгүй байх (гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүй) тохиолдолд захиралтай зөвшилцөн захирлын үүрэг гүйцэтгэгчийг томилж, эрх, үүргийг нь тогтоох;

2.7. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан гүйцэтгэх захирлын зарцуулах зардлын хэмжээг батлах;

2.8. Гүйцэтгэх захирлыг мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, удирдах ажилд мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

2.9. Гүйцэтгэх захирлын гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхтэй холбогдуулж тавьсан саналд тухай бүр хариу өгөх, холбогдох мэдээллээр хангах;

2.10. Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл, аудитын дүгнэлт, гүйцэтгэх захирлын ажлын тайлан, гэрээний биелэлтийг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт

Ажил олгогчийг төлөөлж:

 Ш.Ганзориг

(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:

 П.Баярצעэг

(нэр, гарын үсэг)

өгөх, гүйцэтгэх захиралд олгох урамшууллын хэмжээ, эсвэл хүлээлгэх хариуцлагын талаарх саналаа Хувьцаа эзэмшигчийн хуралд оруулж шийдвэрлүүлэх;

2.11. Ажлын явц, гүйцэтгэлтэй улирал бүр танилцаж санал, зөвлөгөө өгөх, шаардлага тавих;

2.12. Гүйцэтгэх захирал гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол хууль тогтоомж, энэхүү гэрээнд заасны дагуу арга хэмжээ авах, сахилгын шийтгэл ногдуулах;

2.13. Шаардлагатай гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөл компанийн удирдлага, санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд холбогдох яам, газартай хамтран мэргэжлийн хүмүүсийг оролцуулан хяналт шалгалт хийх;

2.14. Гүйцэтгэх удирдлагын буруутай үйл ажиллагааны улмаас байгууллагад хохирол учруулсан нь хуулийн байгууллагаар тогтоогдсон, байгууллагын зорилт эрх ашгийн төлөө шударгаар ажиллах эрх үүргээ хэрэгжүүлээгүй, хамт олны дотор уур амьсгалыг эвдэж, ёс зүйн зөрчил гаргасан, үл ойлголцох байдал үүсгэсэн, үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулсан, ажил олгогчийн итгэлийг алдсан тохиолдолд гүйцэтгэх удирдлагад холбогдох хууль тогтоомж, энэхүү гэрээнд заасны дагуу арга хэмжээ авах, сахилгын шийтгэл ногдуулах, энэхүү гэрээг дангаараа хэдийд ч цуцлах;

2.15. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд заавал оролцох үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, албан ёсны зөвшөөрөлгүйгээр биелүүлээгүй, жилийн ажлын төлөвлөлт хангалтгүй, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлж чадаагүй гүйцэтгэх захирлыг ажлаас чөлөөлж, энэхүү гэрээг нэг талын санаачлагаар цуцлах хүртэл арга хэмжээ авах;


2.16. Хөдөлмөрийн хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 75.2, Иргэний хуулийн 497, 510 дугаар зүйлийг заасны дагуу "Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын тухай гэрээ"-г байгуулж, гэрээнд хавсаргана.

2.17. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Гурав. Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг

3.1. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг Компанийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн

Ажил олгогчийг төлөөлж:


.....Ш.Ганзориг
(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:


.....П.Баярצעэг
(нэр, гарын үсэг)

тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрмийн хүрээнд удирдан зохион байгуулах эрхтэй;

3.2. Компанийн менежментийг боловсронгуй болгох, техник технологийг шинэчлэх, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг үзүүлэлт бүрээр биелүүлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарыг өндөр түвшинд хүргэх, өртөг, зардлыг хямдруулах, өр авлагыг бууруулах, ажилтнуудын нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэж ажиллах үүрэгтэй;

3.3. Компанийг итгэмжлэлгүйгээр гадаад, дотоодод төлөөлөх, итгэмжлэл олгох;

3.4. Өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд бусад хуулийн этгээд, иргэдтэй гэрээ, хэлцэл байгуулах;

3.5. Хүний нөөцийн бодлого боловсруулж батлах;

3.6. Ажилтнуудын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж батлах;

3.7. Гүйцэтгэх захирал дараах асуудлыг зөвхөн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэх, холбогдох шийдвэр гаргуулах үүрэгтэй:

3.7.1. Хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагааны үндсэн чиглэлээс өөр төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

3.7.2. Хууль тогтоомжид нийцүүлэн компанийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөрөнгө олж авах, данснаас хасах, захиалах, шинээр авах;

3.7.3. Компанийн барилга байгууламжийг зохих журмын дагуу түрээслүүлэх, түүнд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл өгөх;

3.7.4. Салбар, төлөөлөгчийн газар байгуулах санал оруулж хэлэлцүүлэх;


3.7.5. Компанийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой зардлын төсөв батлах;

3.7.6. Компанийн дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах;


3.7.7. Сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгуулах;

3.7.8. Их хэмжээний хэлцэл хийх, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох. (Аливаа гэрээ хэлцлийн хугацаа нь энэхүү гэрээний хугацаанаас илүү байж болохгүй)

Ажил олгогчийг төлөөлж:


.....Ш.Ганзориг
(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:


.....П.Баярцэцэг
(нэр, гарын үсэг)

3.7.9. Банк санхүүгийн байгууллагаас зээл авах тохиолдолд Эрчим хүчний яам, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, зөвшөөрлийг гаргуулах;

3.7.10. Компанийн хөрөнгөөс зээл олгох, хандивлах, бэлэг өгөх, бусдад хөрөнгийн баталгаа гаргах;

3.7.11. Компанийн олгох ногдол ашгийн тооцоо;

3.7.12. Үйлдвэрийн газарт осол аваар гарч онцгой нөхцөл байдал үүссэн үед зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг материал худалдан авах;

3.8. Компанийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу эзэмших, ашиглах эрхтэй;

3.9. Гүйцэтгэх захирал нь өмч эзэмшүүлэх гэрээг зохих журмын дагуу байгуулах, дүгнүүлэх;

3.10. Компанийн үйл ажиллагааны цэвэр ашгаас төрийн өмчийн ногдол ашгийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан хувь, хэмжээг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор холбогдох дансанд шилжүүлнэ;

3.11. Компанийн үйлдвэрлэл, технологи, бизнесийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэлийг тогтоох, хамгаалах;

3.12. Гүйцэтгэх захирал холбогдох хууль тогтоомж, журмын дагуу ажилтныг ажилд томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дуусгавар болгох, батлагдсан цалингийн санд багтаан ажилтнуудын цалинг тогтоох;


3.13. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн дагуу анхан шатны бүртгэл хөтлөх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан маягт, аргачлалын дагуу зохих мэдээ, тайланг цаг тухайд нь холбогдох газруудад гаргаж өгөх;

3.14. Гүйцэтгэх захирал гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхгүй бөгөөд бусад этгээдийн өмнө ажил, үүрэг гүйцэтгэхгүй байж, гэрээний биелэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө биечлэн хариуцах;

3.15. Компанийн санхүүгийн тайлан мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу тогтоосон хугацаанд компанийн болон Эрчим хүчний яамны цахим хуудсанд тухай бүр байршуулах;

3.16. Гүйцэтгэх захирал нь компанийн зорилтын санал үйл ажиллагааны зорилтот түвшинг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал дүгнэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу гаргаж, тогтоосон хугацааны дотор холбогдох байгууллагуудад хүргүүлэх;

Ажил олгогчийг төлөөлж

 Ш.Ганзориг

(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:

 П.Баярцэцэг

(нэр, гарын үсэг)

3.17. Төрийн өөрийн өмчийг бусдад түрээслүүлэхэд холбогдох хууль тогтоомж, захиргааны актыг мөрдөн ажиллах бөгөөд түрээсийн төлбөрийг тогтоосон хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дансанд төвлөрүүлэх;

3.18. Компанийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад өдөр тутам хяналт тавьж, эд хөрөнгийн дотоодын тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу явуулах;

3.19. Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тухайн компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар гаргах;

3.20. Эрчим хүчний яам, Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнах;

3.21. Эрх бүхий байгууллагаас тогтоосноос бусад өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох;

3.22. Маргаантай асуудлаар компанийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах;

3.23. Гүйцэтгэх удирдлага болон компанийн эрх бүхий албан тушаалтнууд хамт олныг нэгдсэн удирдлагаар хангах, хамт олны дотор эерэг уур амьсгалыг бүрдүүлэн ажиллах;

3.24. Гүйцэтгэх захирал Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцох, компанийн жилийн ажлын төлөвлөлт, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг оновчтой тодорхойлох;

3.25. Гүйцэтгэх удирдлагын зүгээс хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад хохирол учруулсан буюу ажилтныг хууль зүйн үндэслэлгүй ажлаас халсны улмаас шүүхийн шийдвэрээр ажилд эргүүлэн томилж, байгууллагаас ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг нөхөн олгож, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд нөхөн төлөлт хийсэн тохиолдолд уг хохирлыг өөрийн хувийн эд хөрөнгөөр хариуцна.

3.26. Гүйцэтгэх захирал компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний хүрсэн түвшинг бууруулахгүй байх;

3.27. Албан ажлаар гадаад улсад зорчих, ээлжийн амралтаа эдлэхэд Төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр мэдэгдэж, зөвшөөрөл авах;


3.28. Гүйцэтгэх удирдлага нь хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад хохирол учруулахгүй буюу ажилтныг хууль зүйн үндэслэлгүй ажлаас халахгүй байх үүрэг хүлээнэ. Байгууллагад хохирол учруулсан, ажилтныг ажлаас үндэслэлгүй халсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож ажилд эргүүлэн томилж,

Ажил олгогчийг төлөөлж:

.....Ш.Ганзориг

(нар, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:

.....П.Баярצעэг

(нар, гарын үсэг)

байгууллагаас ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг нөхөн олгож, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд нөхөн төлөлт хийсэн тохиолдолд уг хохирлыг өөрийн хувийн эд хөрөнгөөр хариуцна.

3.29. Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар, журам гаргана.

Дөрөв. Цалин хөлс, урамшуулал, ажлын нөхцөл

4.1. Гүйцэтгэх захиралд албан тушаалын сарын үндсэн цалин 3,564,000 (гурван сая таван зуун жаран дөрвөн мянга) төгрөг олгоно.

4.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх түр журам"-аар гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг дүгнэж, ажлын үр дүнгийн урамшуулал олгох эсэх асуудлыг Хувьцаа эзэмшигчийн хурал эцэслэн шийдвэрлэнэ.


4.3. Ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй гүйцэтгэх захиралд Хамт /тариф/-ын хэлэлцэрийн 3.10-т заасан салбарт тасралтгүй ажиллаж байгаа удаан жил ажилласны нэмэгдлийг тус салбарт ажилласан хугацаанаас хамааруулан албан тушаалын үндсэн цалингийн 35 хувь хүртэл олгох, зөвлөх болон мэргэшсэн инженерийн нэмэгдэл, бусад тусламж, дэмжлэгийг ажилтантай адил эдлэх, "Сарын үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлс"-ийг компанийн хэлтэс, алба, хэсгийн үйл ажиллагааны үр дүнг дүгнэсэн хувийн дунджаар тооцож, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар батлуулан сар бүр олгоно. Сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл гүйцэтгэх захирлын албан тушаалын цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.

4.4. Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн гүйцэтгэх захирлын сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй тохиолдолд сарын болон жилийн үр дүнгийн нэмэгдэл болон урамшуулал олгохгүй.

4.5. Гүйцэтгэх захирлын ээлжийн амралт болон хөдөлмөрийн харилцаатай холбогдон үүсэх, энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дотоод журмаар зохицуулна.

4.6. Гүйцэтгэх захирлыг албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах ажлын байр, суудлын автомашин, техник хэрэгслээр хангана. Орон нутагт болон бусад аймгууд, нийслэлд албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахаас бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно.

Ажил олгогчийг төлөөлж:


.....Ш.Ганзориг
(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:


.....П.Баярцэцэг
(нэр, гарын үсэг)

4.7. Эрчим хүчний яам шаардлагатай тохиолдолд захиралд нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь зориулж 3 сарын үндсэн цалингаас хэтрүүлэхгүй хэмжээний мөнгөн тусламжийг тухайн компанийн санхүүгээс нэг удаа олгож болно.

Тав. Гэрээг цуцлах, дуусгавар болгох

5.1. Гэрээ нь дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно:

5.1.1. Талууд харилцан тохирсон;

5.1.2. Гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон;

5.1.3. Хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллага шаардсан;

5.1.4. Гүйцэтгэх захирал цэргийн жинхэнэ албанд татагдсан;

5.1.5. Гүйцэтгэх захирал гэмт хэрэг үйлдсэний улмаас ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

5.1.6. Гэрээг гүйцэтгэх захирлын буюу ажил олгогчийн санаачилгаар цуцалсан.

5.2. Ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 65, 80 дугаар зүйлд зааснаас гадна дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах эрхтэй:

5.2.1. Хувьцаа эзэмшигчээс гэрээг цуцлах талаар Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж, чиглэл өгсөн бол;

5.2.2. Компани татан буугдсан, дампуурсан;


5.2.3. Компани хувьчлагдаж, төрийн эзэмшлийн хувьцаа худалдагдсан, өмчлөгч өөрчлөгдсөн, өмчлөх эрхээ шилжүүлсэн;

5.2.4. Гүйцэтгэх захирал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

5.2.5. Гүйцэтгэх захирлын буруу шийдвэр, үйл ажиллагаагаар компанид хохирол учирсан, алдагдалд орсон;

5.2.6. Гүйцэтгэх захирал хууль тогтоомж зөрчсөн, компанийг удирдан зохион байгуулах үүргээ биелүүлээгүй;

Ажил олгогчийг төлөөлж:


..... Ш.Ганзориг
(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:


..... П.Баярцэцэг
(нэр, гарын үсэг)

5.2.7. Эрчим хүчний яамны шаардлага, үүрэг даалгавар, хувьцаа эзэмшигч болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн удирдамж, заавар, үүрэг даалгаврыг биелүүлээгүй;

5.2.8. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлээгүйгээс компанид ноцтой осол аваар гарсны улмаас хүний амь нас хохирсон, эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан, компанид их хэмжээний хохирол учирсан;

5.2.9. Өөр ажил олгогчтой хөдөлмөрийн зэрэгцсэн гэрээ байгуулсан;

5.2.10. Гүйцэтгэх захиралд хүлээлгэн өгсөн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, үрэгдүүлсэн, өмчлөгчөөс олгосон эрх мэдлийг хэтрүүлсэн нь нотлогдсон;

5.2.11. Хуульд заасан бусад үндэслэл.

5.3. Ажилтан Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар ажилтны санаачлагаар гэрээг цуцална.

5.4. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсантай холбогдон үүсч болох тэтгэмж, нөхөн олговрын асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дотоод журмын дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг бүрэн хариуцна.


6.2. Гүйцэтгэх захирал нь энэхүү гэрээ, холбогдох журмыг зөрчсөн эсхүл ёс зүйн болон бусад шалтгааны улмаас ажил олгогчийн итгэлийг алдсан тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл нь хэдийд ч энэхүү гэрээг дуусгавар болгох, дангаараа цуцлах болон Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага ногдуулах эрхтэй.

6.3. Гүйцэтгэх захирал нь хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ өөрийн буруугаас компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээхээс бусад тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу зургаан сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээгээр хариуцан арилгах үүрэгтэй.

6.4. Гүйцэтгэх захирал нь эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээх бөгөөд дагалдах гэрээ нь энэхүү гэрээний салшгүй гэрээ болно.

6.5. Гүйцэтгэх захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Иргэний хууль, бусад хууль тогтоомж, компанийн дүрэм, энэ гэрээнд заасан хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэх,

Ажил олгогчийг төлөөлж:


.....Ш.Ганзориг
(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:


.....П.Баярצעэг
(нэр, гарын үсэг)

урвуулан ашиглах зэргээр тухайн компанид хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцаж арилгана.

Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах,

7.1. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэн зохих журмын дагуу баталгаажуулах бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

Найм. Бусад

8.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

8.2. Энэхүү гэрээ нь нийт 10 (арван) хуудас бөгөөд Монгол хэл дээр 3 (гурав) хувь үйлдэж, Эрчим хүчний яам, компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал тус бүр 1 хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй байна.

8.3. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



/гарын үсэг/

"Дулаан Шарын гол" ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
дарга Ш.Ганзориг
Хаяг: Хан-Уул дүүрэг 3-р хороо
Чингисийн өргөн чөлөө, Засгийн
газрын XIV байр,
Утас: 88111425
Регистрийн дугаар: ЧИ75080415
И-мэйл:
ganzorig@energy.gov.mn


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



/гарын үсэг/

"Дулаан Шарын гол" ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирал П.Баярצעэг
Хаяг: Дархан-Уул аймаг Шарын гол
сум
Утас: 99044511
Регистрийн дугаар: ТЯ78082963
И-мэйл:
bayartsetsegbayaraa891@gmail.com

Ажил олгогчийг төлөөлж:


.....Ш.Ганзориг
(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:


.....П.Баярצעэг
(нэр, гарын үсэг)

"Дулаан Шарын гол" ТӨХК-ийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан
"Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний хавсралт

ЭД ХӨРӨНГИЙН БҮРЭН ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ДАГАЛДАХ ГЭРЭЭ

2024 оны 07 дугаар
сарын 04-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Хөдөлмөрийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 75.2, Иргэний хуулийн 497, 510 дугаар зүйлийг тус тус үндэслэн нэг талаас "Дулаан Шарын гол" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ш.Ганзориг /цаашид "ажил олгогч" гэх/, нөгөө талаас "Дулаан Шарын гол" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал ажил (албан тушаал)-тай ТЯ78082963 регистрийн дугаартай иргэн П.Баярцэцэг /цаашид "эд хариуцагч" гэх/ нар харилцан тохиролцож, 2024 оны 07 дугаар сарын 04-ны өдөр байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний хавсралт болгон дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь эд хариуцагч холбогдох хууль тогтоомж, компанийн дотоод журам, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээс компанид эд хөрөнгийн хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг нөхөн төлөх, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад оршино.

1.2. Энэхүү гэрээ нь "Дулаан Шарын гол" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал П.Баярцэцэгт эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх дагалдах гэрээ бөгөөд 2024 оны 07 дугаар сарын 04-ны өдөр харилцан тохиролцсон 2024/01 дүгээр "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний салшгүй хэсэг болно.

1.3. Гэрээний хугацаа нь энэ гэрээний 1.2-т заасан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний 1.2-т зааснаар зохицуулагдана.

Хоёр. Ажил олгогчийн эрх, үүрэг

2.1. Ажил олгогч нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:

2.1.1. Эд хариуцагчид Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 1.3-т заасан эд хөрөнгийг хүлээлгэн өгөх, түүнийг хэвийн байдлаар ашиглах, хамгаалах нөхцөлөөр хангах;

Ажил олгогчийг төлөөлж:

 Ш.Ганзориг

(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:

 П.Баярцэцэг

(нэр, гарын үсэг)

2.1.2. Эд хариуцагчид эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, түүнийг ариг гамтай, зориулалтын дагуу ашиглах, хадгалах, тээвэрлэх, захиран зарцуулах эрхтэй болохыг танилцуулах;

2.1.3. Эд хариуцагчийн буруугаас түүнд хүлээлгэн өгсөн эд зүйлс үгүй болох, эвдрэх, дутагдах тохиолдолд ажил олгогчид учирсан аливаа хохирлыг нөхөн төлүүлэх;

2.1.4. Эд хариуцагчийн гаргасан үйлдэл нь эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй бол харьяалах хуулийн байгууллагад мэдэгдэх, зерчил дутагдлыг арилгах, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.

Гурав. Эд хариуцагчийн эрх, үүрэг

3.1. Эд хариуцагч нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:

3.1.1. Хүлээн авсан эд хөрөнгийг зориулалтын дагуу, ариг гамтай ашиглах, эд хариуцах үүргээ зохистой биелүүлэх;

3.1.2. Албан тушаалаа урвуулан болон хэтрүүлэн ашиглан хууль бус акт үйлдэж эд хөрөнгө, бараа материал завшихгүй байх;

3.1.3. Байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн талаар ажил олгогчид яаралтай мэдэгдэх;

3.1.4. Хариуцсан эд хөрөнгийг тоолох бүртгэхэд биечлэн оролцож, бүртгэсэн баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулах;

3.1.5. Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1-д заасан тохиолдолд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээх;

3.1.6. Хүлээн авсан эд хөрөнгөнд өөрийн буруугаас хохирол учруулбал хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах бөгөөд эд хариуцагч ажлаас гарсан нь энэхүү үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Дөрөв. Талуудын хариуцлага болон маргааныг шийдвэрлэх

4.1. Ажил олгогч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн зохистой биелүүлээгүйгээс шалтгаалж эд хөрөнгийн хохирол гарахад хүрвэл, гэм буруугийн хэмжээгээр эд хариуцагчийн хүлээх бүрэн хариуцлагыг багасгах буюу чөлөөлөх үүрэгтэй.


4.2. Эд хариуцагчийн буруугаас эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээх тохиолдолд ажил олгогч нь хохирлын хэмжээг зах зээлийн үнэ, нягтлан бодох бүртгэлд тусгагдсан өртгийг харгалзан бодитоор тогтоож, акт үйлдэнэ.

4.3. Эд хөрөнгийн хохирлын хэмжээтэй холбогдуулан талууд зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Ажил олгогчийг төлөөлж:


.....Ш.Ганзориг
(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:


.....П.Баярцэцэг
(нэр, гарын үсэг)

Тав. Гэрээний бусад нөхцөл

5.1. Энэхүү гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, гэрээнд хавсаргана. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байна.

5.2. Энэхүү гэрээг "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний 8.2-д заасны дагуу 3 хувь үйлдэж, Эрчим хүчний яам, компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал тус бүр 1 хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй байна.

5.3. Гэрээнд тусгаагүй бусад асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

АЖИЛ ОЛГОГЧИЙГ
төлөөлж


/гарын үсэг/

"ДУЛААН ШАРЫН ГОЛ"
ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Ш.ГАНЗОРИГ

ЭД ХАРИУЦАГЧ:


/гарын үсэг/

"ДУЛААН ШАРЫН ГОЛ"
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ П.БАЯРЦЭЦЭГ

Ажил олгогчийг төлөөлж:

.....Ш.Ганзориг
(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал:

.....П.Баярצעэг
(нэр, гарын үсэг)